



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 5/72

Хэрлэн сум

Ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Засгийн газрын 2007 оны "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" тухай 354, 2014 оны "Төрийн зарим албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 75 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн Бор-Өндөр сумын "Энхжин" цэцэрлэгийн эрхлэгчээр Р.Мөнгөнтуулыг, "Бүжинхэн" цэцэрлэгийн эрхлэгчээр Ө.Нарантуяаг тус тус томилсугай.

2. Цэцэрлэгийн эрхлэгч нарын ажлыг хүлээлцэх комисс томилон ажиллуулахыг сумын Засаг дарга /П.Чинбат/-д даалгасугай.

3. Эрхлэгч нарын цалинг ТҮБД-н 6-ын 5 дугаар шатлал 711230 /долоон зуун арван нэгэн мянга хоёр зуун гучин/ төгрөгөөр тогтоож, цалинжуулахыг цэцэрлэгийн нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

4. Эрхлэгч нарын ажлыг мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА